

Анги, бүлэг:

ШИФР:.....

**8 ДУГААР АНГИЙН ТҮҮХ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР
ХУВИЛБАР “А”**

ХУГАЦАА: 80 МИН

1. Монгол улс төрийн төв эх нутагтаа хэзээ шилжсэн бэ? /2 оноо/
a.1368 b.1634 c. 1260 e.1206 f.1402
2. 1368-1634 он хүртэл Монголын төрийг 22 хаан төр барьсан ба энэ үеийг юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/
a. Бутралын үе b.Бага хаадын үе c.Улс төрийн самууны үе.
d.Өв залгамжлалын үе e.Зөв хариулт алга
3. 1492 оны 10-р сарын 12-нь Төв америкын арлуудад анх хүрснийг Америк тив нээгдсэн өдөр гэдэг. Тэгвэл уг газар очсон хүн хэн бэ? /2 оноо/
a. X. Колумб b.Ф. Магеллан c. Васка да Гама d.Жеймс Кук e.Зөв хариулт алга
4. Орон нутгийн сүмийн хаалган дээр өөрийн үзэл санааг илэрхийлсэн 95 зүйл бүхий бичгийг наасан профессор, санваартан хэн бэ? /2 оноо/
a.Гэгээн Павел b.Иохан Тецель c. Мартин Лютер d. Ж. Кальвин e.Зөв хариулт алга
5. Японы уламжлалт шүтлэгийг юу гэдэг вэ? /2 оноо/
a.Харакири b.Шинто c.Ниппон d.Камиказе e. Зөв хариулт алга
6. Энэ хүн “эзэн хаанд бараалхана” гэж гараад Алтайн цаана Өрөнгө голд хүрч ирмэгцээ шадар 300 цэргээ удирдан 1755 оны 9 сарын 24-нд бослого гаргаснаар 1755-1758 оны Монголчуудын тусгаар тогтнолын зэвсэгт бослого эхэлжээ. Энэ бослогыг эхлүүлсэн хүн хэн бэ? /2 оноо/
a.Чингүнжав b.Амарсанаа c.Инжинаш d.Галдан бошогт e.Даваач
- 7.Эдгээрээс хэн нь тухайн цаг үед Одоогийн Дорнод аймгийн Халх гол сумын нутагт буй Хулд уулыг Манжид алдалгүй авч үлдсэн бэ? /2 оноо/
a.Чингүнжав b.Амарсанаа c.То ван Тогтохтөр d.Галдан e.Өндөр Гэгээн
- 8.Манж Чин улс монголчуудыг эрхшээлдээ оруулаад тэднийг барьж, захирч байхад чиглэгдсэн засаг захиргааны зохион байгуулалтыг тогтоов. Тэд монголчуудыг эрхшээлдээ хянан захирч байх төрийн бодлогоо хэрэгжүүлэх зорилгоор дараах газрыг байгуулжээ. Энэ ямар газар вэ? /2 оноо/
a.Улиастайн жанжны газар b.Ховдын хязгаарын газар c.Хүрээний газар d.Гадаад монголын төрийг засах явдлын яам e. 9 эрүү шүүлтийн газар
9. 1733 онд Жон Кей гэх хүн аль зүйлийг нь бүтээсэн бэ? /2 оноо/
a. Нэхмэлийн суурь машин. b. Уурын хөдөлгүүр c. Дотоод шаталтын хөдөлгүүр
d. Зүйлийн үүсэл e. Цахилгаан дэнлүү
10. Эдмунд Картрайтын зохин бүтээсэн нэхмэлийн суурь машин хөдөлмөрийн бүтээмжийг хэд дахин нэмэгдүүлсэн бэ? /2 оноо/
A. 3 b. 30 C.40 D.56 E.60
11. “Наполеоны хуулиуд”-ыг арай өөрөөр хэрхэн нэрлэдэг вэ? /2 оноо/
A. Кодекс В.Примокс C.Легитим. d. Легаль. E.Харизмат
12. Доорх хаадаас хэн нь Даян хаан хэмээх цолтой вэ? /2 оноо/
A. Батмөнх B. Алтан хан C.Лигдэн. d. Эсэн тайш e. Түмэн засагт хан
13. Доорх хаадаас хэн нь “ЗАСАГТ ХААН” хэмээн алдаршсан бэ? /2 оноо/
A.Батмөнх даян хаан B.Алтан хан C.Лигдэн E. Эсэн тайш
- 14.1639 онд Халхын ноёд Ширээ цагаан нуур гэдэг газар чуулж, Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг 5 настайд нь Халх Монголын тэргүүнд өргөмжилөв. /2 оноо/
A.Улс төрийн b. Хаан ширээний c. Шарын шашны. D. Улааны шашны E. Бөөгийн
- 15.“Хуулийн амин сүнс” хэмээх бүтээлдээ хаант засаглалыг гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх гэсэн гурван хэсгээс бүрддэг гэж үзсэн эрдэмтэн хэн бэ? /2 оноо/
A.Ж. Локк b. Ж. Ж. Руссо c.И. Кант d.Ш. Монтескье e.Зөв хариулт алга

16.“Нар орчлонгийн төвд байдаг. Харин манай гараг бол ертөнцийн хөдөлгөөнгүй төв биш, бусад 6 гарагийн 3 дахь нь болж нарыг тойрон эргэлддэг” гэсэн дүгнэлтийг хэн хийсэн бэ? /2 оноо/

А.Иоханнес Гутенберг В.Галилео Галилей С.Чарльз Дарвин Д.Николас Коперник Е.Леонарда да Винчи

17.1525 онд Хойд Энэтхэгийг эзэлж, “шах”-аар өргөмжлөгдсөн хүн бэ? /2 оноо/

А.Акбар В.Ауранзэв С. Бабур Д. Дээрх бүгд зөв Е. Дээрх бүгд буруу

18. Халхын Очирбат Түшээт хан Абтайгийн 1586 онд байгуулсан хийдийг олно уу? /2 оноо/

А.Амарбаясгалант б. Манзушир с. Эрдэнэзуу d.Гүнжийн сүм е.Төвхөн хийд

19. XVIII-XX зуун эхэн үед Монголын сургууль соёлын салбарт аль сургууль нь давамгайлж байсан бэ? /2 оноо/

А.Гэрийн сургууль В.Шашны сургууль С.Хаадын сургууль Д. Лам нарын сургууль. Е.Албаны сургууль

20. Манжийн элч төлөөлөгчид, цэрэг, албан бичиг зэргийг яаралтай нэвтрүүлэн хүргэх зориулалттай цэрэгжүүлсэн газрыг юу гэдэг вэ? /2 оноо/

А.Өртөө В.Буухиа өртөө С.Албан газар Д.Албан өртөө Е. Сум

21.Өвдөлт намдаах үйлчилгээтэй химийн бодисуудыг өвчин намдаагч, бүх мэдрэхүйг үгүй болгодог бодисыг мэдээ алдуулагч гэж нэрлэсэн хүн хэн бэ? /2 оноо/

А. Вандэлл Холмс. В.Ричард Трэвитик. С.Жорж Стенфенсон

Д.Томас Эдисон Е.Александр Грехем Белл

22. Британий байгаль судлаач Чарлз Дарвин олон жилийн ажиглалт, судалгааныхаа үр дүнд аль бүтээлийг нь гаргасан бэ? /2 оноо/

А. Нэхмэлийн суурь машин В. Уурын хөдөлгүүр. С.Дотоод шаталтын хөдөлгүүр

Д.Зүйлийн үүсэл Е.Цахилгаан дэнлүү

23. “Суут хүн гэдэг нэг хувийн авьяас, ерөн есөн хувийн хичээл, зүтгэл” гэж хэн хэлсэн бэ? /2 оноо/

А. Вандэлл Холмс. В.Ричард Трэвитик. С.Жорж Стенфенсон

Д.Томас Эдисон Е.Александр Грехем Белл

24. Зөв харгалзуулна уу? /2 оноо/

1	Дөрвөн Ойрад	А	Ордос, Түмэд, Юншээбүү, Асуд, Харчин
2	Зүүн гар	В	Халх, Цахар, Урианхай
3	Баруун гар	С	Хошууд, Торгууд, Дөрвөд, Чорос

А.1a2b3c

В.1b2c3a

С.1c2b3a

Д.1c2a3b

Е.1a2c3b

25. 1368-1634 он хүртэл Монголын төрийг 22 хаан төр барьсан ба энэ үеийг юу гэж нэрлэдэг вэ? /2оноо/

А.Бутралын үе В.Бага хаадын үе С.Улс төрийн самууны үе.

Д.Өв залгамжлалын үе Е.Зөв хариулт алга

26. Монголчуудын тусгаар тогтнолоо алдсан оныг харгалзуулна уу? /2 оноо/

А. Өвөр Монгол 1. 1755 он А.А2 В2 С1 В.А1 В2 С3 С.А3 В1 С2

Б. Халх Монгол 2. 1636 он

В. Баруун Монгол 3. 1691 он

27. Мин улсын нийслэл аль нь биш вэ? /2оноо/

А. Бээжин В.Нанжин С.Ганьсу

28. Их Могол улсын шах Жаханы зарлигаар 1630-1653 онд бүтээн байгуулагдсан байгууламжыг юу гэдэг вэ? /2оноо/


А.Таж Махал В.Пирамид С.Цагаан хэрэм Д.Хааны ордон Е.Үлгэрийн орд

29. “Ялагдашгүй Армада” гэж юу вэ? /2оноо/

А.Усан флот В.Улсын хоч С.Хамтран дайтагчид

Д.Бичлэгдэшгүй төлөвлөгөө Е.Хөлбөмбөгийн баг

30. Уг зүйлийг юу гэдэг вэ? /2 оноо/



A. Цацарган тойрог B.Заргын бичиг C.Өрийн бичиг D.Данс тооцоо E. Хүн амын тооллого

31. Зөв Холбоорой. /2 оноо/

1	Али-Гали	A	Аюуш гүүш
2	Тод үсэг	B	Зая бандид Намхайжамц
3	Соёмбо үсэг	C	Өндөр гэгээн Занабазар

A.1A2B3C B. 1B2A3C C. 1C2B3A D.1A2C3B E. 1B2C3A

32. 1757 оны 6 сарын 30-нд энэ гэдэг газар Амарсанаа болон Манжийн их цэргийн жанжин Халхын Цэнгүнжав нарын хооронд сүүлчийн шийдвэрлэх тулалдаан болж Амарсанаа хэд дахин давуу хүчинд цохигдон цөөн хүний хамт Орос руу зугтан оджээ. Энэ үйл явдал ямар газарт болсон бэ? /2оноо/

A.Шарбэл B. Цэцэг C.Алтай D.Улаангом

33. Олон улсын хэмжүүрийн нэгжийн тогтолцоо аль нь вэ? /2оноо/

A.Хүндийн жин B.Ватт C.Кш D.Си тогтолцоо E.Бүгд зөв

34. XVII-XX зууны эхэн үед дорно дахинд аль улс хүчирхэгээр оршин тогтнож байсан бэ? /2оноо/

A.Мин B.Манж Чин C.Япон D.Моголын эзэнт гүрэн

35. Япон орон улс төр, эдийн засгийн асар том өөрчлөлтийг аль шинэчлэлээр хийсэн бэ? /2оноо/

A.Рюүкюүгийн шинэчлэл B.Мэйжийн шинэчлэл C.Токугавагийн шинэчлэл

D.Их эзэн хаана шинэчлэл E.Ниппоны шинэчлэл

36. Зөв харгалзуулна уу? /6 оноо/

1E	Эсэн тайш	A	
2A	Батмөнх даян хаан	B	
3D	Түмэн засагт хаан	C	
4C	Лигдэн хутагт хаан	D	
5B	Галдан бошогт	E	

37. Дараах 2 шашны урсгалуудыг тайлбарлан бичнэ үү? /6 оноо/

Кальвинизм	
------------	--

Лютерийн урсгал	
-----------------	--

38. XIX зууны сүүлчээс Чин гүрэн бодлогоо өөрчилж, “Шинэ засгийн бодлого” хэрэгжүүлэв. Энэ нь ямар бодлого байсан бэ? /6 оноо/

39. Зөв харгалзуулна уу? /6 оноо/

1	Колони	A	Хүчирхэг улс гүрнүүдийн хөгжил буурай, эзэнгүй, хүн ам цөөтэй нутаг дэвсгэрт ноёрхлоо тогтоон уугуул нутгийнхныг засаглан захирах, соёлоо дэлгэрүүлэх, шилжин суурьших үйл явц
2	Хагас Колони	B	Улс төр, эдийн засгийн хувьд бусдын хараат байдалд, хяналтанд орсон орон юм
3	Хараат орон	C	Улс төр, эдийн засгийн бүх эрх мэдлээ бусдад бүрэн алдсан орныг хэлдэг
4	Хар тамхи	D	Улс төр, эдийн засгийн хувьд хэлбэрийн төдий тусгаар тогтносон боловч эдийн засгийн эрх мэдэлгүй болсон орон юм
5	Колоничлол	E	Хүний уураг тархи, мэдрэл сэтгэхүйд хүчтэй нөлөөлдөг ургамлын гаралтай мансууруулах бодис юм. Уг бодис хүний бие махбодод төдийгүй сэтгэцэд аймшигтай муугаар нөлөөлдөг маш хортой

40. Хагас колони орны жишээг бичнэ үү? /6 оноо/